

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АШГИЙН ТӨЛӨӨ БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн баталгааг хангах, иргэний нийгмийн хөгжлийг дэмжих, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн байдал, үйл ажиллагаатай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хууль тогтоомж

2.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль³ болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Үйлдвэрчний эвлэл, Улаан загалмай нийгэмлэг, Нотариатчдын танхим, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Шинжлэх ухааны академи зэрэг хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн үйл ажиллагааг холбогдох хууль, холбогдох хуульд тусгагдаагүй бусад нийтлэг харилцааг нь энэ хуулиар зохицуулна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны ... дугаарт нийтлэгдсэн.

3.2.Засгийн газрын тусгай сан, хөрөнгө оруулалтын сан болон улс төрийн нам, улс төрийн намын дэргэдэх байгууллага, шашны байгууллагад энэ хууль үйлчлэхгүй.

3.3.Ашгийн бус үйл ажиллагаа явуулах зорилгоор хэд хэдэн этгээд нэгдэн бүртгэгдээгүй холбоо байгуулж болно. Бүртгэгдээгүй холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд холбогдон үүсэх харилцааг Иргэний хуулийн 481, 482 дугаар зүйлээр зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо

4.1.Энэ хуульд заасан дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“ашгийн төлөө бус хуулийн этгээд” гэж төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс бусад хуулийн этгээд, иргэдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулсан, үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг, аливаа хэлбэрээр ашиг хуваарилдаггүй хуулийн этгээдийг;

4.1.2.“холбоо” гэж нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

4.1.3.”сан” гэж нэг, эсхүл хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

4.1.4.“эрх барих байгууллага” гэж холбооны бүх гишүүдийн хурал, сангийн удирдах зөвлөлийг;

4.1.5.“удирдах байгууллага” гэж холбооны удирдах зөвлөл, сангийн гүйцэтгэх удирдлагыг;

4.1.6.“нийтэд тустай үйл ажиллагаа” гэж энэ хуулийн 44.2-т заасан үйл ажиллагааг;

4.1.7. “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэж хуулийн дагуу нийтийн эрх ашгийн төлөө байгуулагдаж, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх үүргийг хүлээсэн, зохион байгуулалт, үйл ажиллагааг хууль, өөрийн дүрмээр нарийвчлан зохицуулдаг, төрийн зохицуулалт бүхий холбоог.

5 дугаар зүйл.Төр, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн харилцаа

5.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар хууль тогтоомжид заасны дагуу явуулна.

5.2.Төрийн байгууллага нь үл ялгаварлах, тэгш боломж олгох, нээлттэй байх зарчмыг баримтлан хууль тогтоомжид заасан хүрээнд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжих, харилцах, хамтран ажиллах үүрэгтэй.

5.3.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь Улсын Их Хурал, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргах бодлого, шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад хуульд заасны дагуу оролцох эрхтэй.

5.4.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь Улсын Их Хурал, төрийн захиргааны байгууллага, орон нутгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульд заасны дагуу мэдээлэл олж авах, түгээх, өөрийн байр сууриа илэрхийлэх эрхтэй.

6 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хориглох зүйл

6.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь өөрийн зорилго, үйл ажиллагаагаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг зөрчихийг хориглоно.

6.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээд доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

6.2.1.улс төрийн нам, улс төрийн намын байгууллага, улс төрийн хөдөлгөөнд нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулах;

6.2.2.шашны байгууллагаас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах;

6.2.3.үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө ажиллах, аливаа хэлбэрээр ашиг хуваарилах;

6.2.4.улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид хандив өгөх, дэмжлэг үзүүлэх;

6.2.5.хууль болон дүрэмдээ зааснаас бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

6.2.6.хуульд зааснаас бусад тохиолдолд иргэдийн эвлэлдэн нэгдэх, ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулах, гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс татгалзах эрхийг нь хязгаарлах;

6.2.7.хуулиар хориглосон бусад.

6.3. Дараахь шинжийг агуулсан бол ашгийн төлөө бус хуулийн этгээдийн удирдлага, гишүүний шийдвэр, үйл ажиллагааг тухайн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн шийдвэр, үйл ажиллагаанд тооцно:

6.3.1. төлөөлөх эрх бүхий этгээд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхолын төлөө дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргасан, эсхүл зөвшөөрөл өгсөн бол;

6.3.2. хуулийн этгээдийн ашиг сонирхолын төлөө үйл ажиллагаа явуулсан, эсхүл бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол.

7. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалд төрийн үйлчилгээний албан тушаалтнаас бусад төрийн албан тушаалтан, улс төрийн намын удирдлага, намын санхүүгийн албаны дарга, ерөнхий менежер, түүнтэй адилтгах албан тушаалтан ажиллахыг хориглоно.

Тайлар: Энэх хуульд заасан “ашиг хуваарилах” гэдгийг хууль болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасныг зөрчин тухайн хуулийн этгээдийн хөрөнгө, аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлогоос бусдад хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг ойлгоно.

7 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч

7.1. Хуульд өөрөөр заагаагүй бол ашгийн төлөө бус хуулийн этгээдийг дараахь этгээд үүсгэн байгуулж болно:

7.1.1. Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн;

7.1.2. төрийн байгууллага, улсын төсөвт болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс бусад хуулийн этгээд;

7.1.2. Монгол Улсад хувийн хэргээр байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн.

7.2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5-д заасны дагуу энэ хуулиар гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсад ашгийн төлөө бус хуулийн этгээд байгуулах эрхэнд хязгаарлалт тогтоож болно.

8 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэр

8.1. Ашгийн төлөө бус хуулийн этгээд өөрийн нэртэй байна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэр түүний зохион байгуулалт, хэлбэрийг тусгасан байна.

8.2. Холбооны хэлбэрээр байгуулагдсан ашгийн төлөө бус хуулийн этгээд нь өөрийн оноосон нэрний ард “бүртгэгдсэн холбоо” гэж, сангийн хэлбэрээр байгуулагдсан ашгийн төлөө бус хуулийн этгээд нь санхүүжүүлэгчийн төрлөөс хамаарч оноосон нэрийнхээ ард “нийтийн сан”, “хувийн сан” гэж, мэргэжлийн холбоо нь “мэргэжлийн холбоо” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

8.3. Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь нийгэмлэг, сургууль, хүрээлэн, театр, музей, эмнэлэг, төв, клуб, товчоо зэрэг үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон үгийг нэрэндээ оролцуулж болно.

8.4. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулах зорилго бүхий ижил чиглэлийн болон төстэй үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдүүд нэгдэж, эсхүл хуулиар байгуулагдсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь МОНГОЛ, МОНГОЛЫН, ҮНДЭСНИЙ гэсэн үг оролцсон нэртэй байж болохгүй.

8.5. Олон улсын байгууллага болон гадаад улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газраас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь ДЭЛХИЙН, АЗИЙН зэргээр тив, бүс нутгийн нэр, түүнийг төлөөлсөн үг оролцуулсан нэртэй байж болохгүй.

8.6. Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь холбогдох байгууллагад бүртгүүлсэн өөрийн бэлгэдэлтэй байж болно.

9 дүгээр зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэх

9.1. Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн үеэс эхлэн хуулийн этгээдийн эрх эдэлж, өөрийн нэрээр үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.

9.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасахтай холбогдох харилцааг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэм

10.1. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэм нь байгууллагын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн урт хугацааны төлөвлөлт байна.

10.2. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд дараахь зүйлийг тусгана:

10.2.1. нэр, оршин байгаа газар, хууль ёсны хаяг;

10.2.2.зорилго, үйл ажиллагааны чиглэл;
10.2.3.байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд, түүний эрх хэмжээ;
10.2.4.байгууллагын бүтэц, зохион байгуулалт;
10.2.5.дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, журам;
10.2.6.өөрчлөн байгуулах, татан буулгах үндэслэл, журам;
10.2.7.санхүүжилтийн эх үүсвэр;
10.2.8.хөрөнгийг бүртгэх, шилжүүлэх журам;
10.2.9.холбооны хувьд гишүүнчлэлийн төрөл, хэлбэр, гишүүний эрх, үүрэг, гишүүний татварын хэмжээ, гишүүн элсүүлэх, гишүүнчлэлээс хасах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, журам;

10.2.10.энэ хуульд заасан бусад.

10.3.Хувийн сангийн дүрэмд энэ хуулийн 10.2.7-д заасны дагуу санхүүжүүлэгч нь хуулийн этгээд бол оноосон нэр, хувь хүн бол овог, өөрийн болон эцэг, эхийн нэр, санхүүжүүлэгч тус бүр тухайн сангийн санхүүжилтийн хэдэн хувийг хариуцах талаархи мэдээллийг тусгана.

10.4.Дүрэмд зөвхөн эрх барих байгууллагын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж, өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

11 дүгээр зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх

11.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь дүрэмдээ заасан зорилгын хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болно.

11.2.Аж ахуйн үйл ажиллагаа нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн зорилго, гол үйл ажиллагаа байж болохгүй.

11.3.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийг дүрэмд заасан эрх бүхий этгээд гаргана.

11.4.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны орлогод дараахь орлого хамаарна:

11.4.1.хандив, хөрөнгө цуглуулах зорилготой төлбөртэй ажил, үйлчилгээний орлого;

11.4.2.хууль болон дүрмийн зорилготой шууд холбоотой үйлчилгээний төлбөр;

11.4.3.өөрийн хөрөнгөө борлуулсан, түрээсэлсний орлого, хувьцаа, хүүгийн орлого;

11.4.4.хуульд нийцсэн бусад үйл ажиллагааны орлого.

11.5.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулна.

11.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг гишүүд, үүсгэн байгуулагчид, гэрээгээр ажиллагсад болон бусад этгээдэд шууд болон шууд бус хэлбэрээр хуваарилахыг хориглоно.

12 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдээс төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх

12.1.Төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг ашгийн төлөө бус хуулийн этгээд хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно.

12.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болох төрийн чиг үүргийн жагсаалтыг Засгийн газар батална.

12.3.Төрөөс энэ хуулийн 12.1-д заасны дагуу ашгийн төлөө бус хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулахад дараахь зарчмыг баримтлана:

12.3.1.ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хараат бус байдлыг хүндэтгэх;

12.3.2.үл ялгаварлах, тэгш боломж олгох;

12.3.3.нээлттэй ил тод байх;

12.3.4.өрсөлдөөний хязгаарлахгүй байх;

12.3.5 ашиг сонирхлын зөрчилгүй байх.

12.4.Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн онцлогоос хамаарч хууль болон гэрээгээр тусгай нөхцөл, шаардлага тогтоосныг энэ хуулийн 12.3.2, 12.3.4-т заасныг зөрчсөнд тооцохгүй.

12.5.Төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг олон улсын болон гадаад улсын ашгийн бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газраар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхийг хориглоно.

13 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тайлан

13.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь хууль, эсхүл дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа тайлагнана.

13.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь хуульд заасан журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

13.3.Нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээд, нийтийн сан нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа дараа жилийн эхний улиралд багтаан Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд ирүүлнэ.

13.4.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг гэрээний дагуу гүйцэтгэсэн бол тус үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гэрээнд заасан журмаар гэрээ байгуулсан төрийн байгууллагад, дараа жилийн эхний улиралд багтаан Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд ирүүлнэ.

13.5.Энэ хуулийн 13.3, 13.4-т зааснаас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд ирүүлж болно.

13.6.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тайланг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл болон энэ хуулийн 13.4-т заасан холбогдох төрийн байгууллага цахим хуудсандаа байршуулна.

13.7.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайлангийн маягт, тайлагнах журмыг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл батална.

13.8.Энэ хуулийн 13.3-т заасан ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа хагас жил тутам гаргаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.

13.9.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжүүлэгч болон хамтран ажилладаг бусад этгээдэд тайлагнах үүрэг нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээ, хэлцлээр тодорхойлогдоно.

14 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилт

14.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

14.1.1.хууль болон дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

14.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж;

14.1.3.нийтэд тустай үйл ажиллагаа явуулсны нь төлөө төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

14.1.4.холбооны хувьд гишүүний татвар;

14.1.5.хууль тогтоомжийн дагуу олсон бусад эх үүсвэр.

14.2.Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдэлийг бусниулах, экстремист үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүнээс болон хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно.

15 дугаар зүйл.Салбар, төлөөлөгчийн газар

15.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.

15.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд түүний эрх, үүргийг тухайн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрмээр тодорхойлно.

15.3.Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг тухайн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасан эрх бүхий байгууллага томилно.

15.4.Салбар, төлөөлөгчийн газар нь гагцхүү түүнийг байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

15.5.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь улсын бүртгэлд бүртгүүлнэ.

15.6.Олон улсын байгууллага болон гадаад улсын ашийн төлөө бус хуулийн этгээд нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа Монгол Улсад байгуулж болно.

15.7.Олон улсын байгууллага болон гадаад улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.

15.8.Олон улсын байгууллага болон гадаад улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь энэ хуулийн 6, 11, 13, 14 дугаар зүйлд заасан зохицуулалтыг нэгэн адил дагаж мөрдөнө.

16 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах

16.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг түүний эрх барих байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулж болно.

16.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээд зохион байгуулалтын хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдахыг хориглоно.

16.3.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг өөрчлөн байгуулсан бол Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

17 дугаар зүйл.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах

17.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг дараахь үндэслэлээр татан буулгаж болно:

17.1.1.үйл ажиллагаа явуулах хугацаа дууссан, зорилгодоо хүрсэн, эсхүл дүрэмд заасан бусад үндэслэлээр сайн дураараа татан буугдах талаар эрх барих байгууллагын шийдвэр гарсан;

17.1.2.дампуурсанд тооцогдсон;

17.1.3.энэ хуулийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 -д заасныг зөрчсөн нь тогтоогдсон;

17.1.4.Эрүүгийн хуульд заасан татан буулгах арга хэмжээ авагдсан;

17.1.5.хуульд заасан бусад.

17.2.Шүүх энэ хуулийн 17.1.2, 17.1.3, 17.1.4-т заасан үндэслэлээр ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгана.

17.3.Энэ хуулийн 17.1.3-т заасан үндэслэлээр Дампуурлын тухай хуульд заасан нэхэмжлэгч, хариуцагч, мөн хуулийн 17.1.4-т заасан үндэслэлээр сонирхогч этгээд ашгийн бус хуулийн этгээдийг татан буулгах тухай гомдлыг шүүхэд гаргаж болно.

17.4.Шүүх энэ хуулийн 17.2-т заасан үндэслэлээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийг шинжээчээр оролцуулж болно.

17.5.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гаргасан эрх бүхий этгээд шийдвэрээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагад болон Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд мэдэгдэнэ.

18 дугаар зүйл.Татан буугдах үеийн эд хөрөнгийн зохицуулалт

18.1.Татан буугдаж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хөрөнгөөс шаардах эрх бүхий харилцагчийн үүргийн гүйцэтгэлийг дараа үлдсэн эд хөрөнгийг бусдад хуваарилан олгохыг хориглоно.

18.2.Татан буугдаж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх барих байгууллага нь үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн ашгийн төлөө бус хуулийн этгээдэд шилжүүлэхээр шийдвэрлэж болно.

18.3.Хэрэв энэ хуулийн 18.2-т заасан шийдвэр гараагүй бол үлдсэн хөрөнгийг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн шийдвэрээр түүнтэй зорилго нэг буюу ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн ашгийн төлөө бус хуулийн этгээдэд, ийм этгээд байхгүй тохиолдолд түүний дүрэмд заасан зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зориулан зарцуулахаар Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих санд шилжүүлнэ.

18.3.Энэ хуулийн 18.2 -т заасан шийдвэрийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагаас томилогдсон татан буулгах комисс гаргана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

19 дүгээр зүйл.Холбооны байгууллага

19.1.Холбооны эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

19.2.Холбооны удирдах байгууллага нь удирдах зөвлөл байна.

20 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлын бүрэн эрх

20.1.Бүх гишүүдийн хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.1.1.дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

20.1.2.удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, огцруулах;

20.1.3.холбооны жилийн төсвийн төслийг батлах, санхүүгийн болон

үйл

ажиллагааны тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх;

20.1.4.холбоонд гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх тухай шийдвэр гаргах;

20.1.5.салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах;

20.1.6.гишүүн нь өөр холбоо, сангийн гишүүн, үүсгэн байгуулагч болох эсэх асуудлаар шийдвэр гаргах;

20.1.7.холбоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

20.1.8.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

20.2.Бүх гишүүдийн хурал ээлжит болон ээлжит бус хуралдааны хэлбэрээр бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

20.3.Холбооны дүрмээр энэ хуулийн 20.1.4-т заасан холбооны бүх гишүүдийн хурлын эрхийг удирдах зөвлөлд шилжүүлж болно.

21 дүгээр зүйл.Холбоо байгуулах

21.1.Холбоо байгуулахаар тохиролцсон 5-аас доошгүй этгээд холбоог үүсгэн байгуулна.

21.2.Холбоо үүсгэн байгуулах хурлыг энэ хуулийн 21.1-т заасан этгээдүүд зохион байгуулж, уг хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 21.2.1.холбоо үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргах;
- 21.2.2.холбооны дүрмийг батлах;
- 21.2.3.удирдах зөвлөлийг сонгох;
- 21.2.4.холбооны тэмдэг, хэвлэмэл хуудасны загвар батлах.

22 дугаар зүйл.Холбоонд гишүүн элсүүлэх

22.1.Холбооны гишүүнчлэл сайн дурын байна.

22.2.Холбоо байгуулагдсаны дараа түүнд гишүүнээр элсэх, гишүүнээс гарах эрх нээлттэй байна.

22.3.Дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүн элсүүлэх тухай шийдвэрийг бүх гишүүдийн хурал гаргана.

22.4.Холбоо гишүүдийн бүртгэлийг заавал хөтлөнө.

22.5.Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн холбоонд гишүүнээр элсэхэд тавих шаардлага, шалгуурыг холбооны дүрмээр тодорхойлно.

23 дугаар зүйл.Холбооны гишүүнчлэл дуусгавар болох үндэслэл

23.1.Холбооны гишүүнчлэл дараахь үндэслэлээр дуусгавар болно:

23.1.1.өөрийн хүсэлтээр холбооны гишүүнээс гарсан;
23.1.2.гишүүн нас барсан, эсхүл шүүхээс тухайн хүнийг эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцсон, гишүүн байгууллага татан буугдсан;

- 23.1.3.холбооны үйл ажиллагаа дуусгавар болсон;
- 23.1.4.холбооны гишүүнчлэлээс хасагдсан.

23.2.Гишүүнчлэл нь дуусгавар болсон этгээдийн тухайн холбоонд төлсөн гишүүний татварыг буцаан олгохгүй.

23.4.Холбооны гишүүнээс гарахдаа энэ тухайгаа бичгээр мэдэгдэнэ.

24 дүгээр зүйл.Холбооны гишүүнчлэлээс хасах

24.1.Холбооны гишүүнчлэлээс зөвхөн дүрэмд заасан үндэслэлээр хасна.

24.2.Холбооны дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүнчлэлээс хасах шийдвэрийг бүх гишүүдийн хурал гаргана.

24.3.Холбооны гишүүнчлэлээс хасах шийдвэр гаргах хуралд тухайн гишүүн, гишүүн байгууллагын төлөөллийг биечлэн оролцуулна. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд оролцоогүй бол түүний эзгүйд уг шийдвэрийг гаргаж болно.

24.4.Гишүүнчлэлээс хасах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэрийг тухайн этгээдэд даруй бичгээр мэдэгдэнэ.

24.5.Гишүүнчлэлээс хасах тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ тухай шүүхэд гомдол гаргаж болно.

24.6.Холбооны үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар оролцоогүй, дүрмээр тогтоосон хугацаанд татвараа удаа дараа төлөөгүй гишүүний эрхийг тодорхой хугацааны дараа шууд зогсоох, тухайн холбооны гишүүнээс хасах тухай дүрэмд зааж болно.

25 дугаар зүйл.Холбооны гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх

25.1.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эрх, үүргээ биечлэн болон төлөөллөөрөө дамжуулан хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд өөрийнх нь хүсэлтээр холбооны гишүүний эрхийг түдгэлзүүлж болно.

25.2.Холбооны гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх үндэслэл, хугацааг холбооны дүрмээр тогтооно.

25.2.Холбооны дүрэмд заасан бол гишүүний эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн гишүүнийг татвараас чөлөөлж болно.

26 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах

26.1.Дүрэмд өөрөөр заагаагүй бол бүх гишүүдийн ээлжит хурлыг жилд нэг удаа зарлан хуралдуулна.

26.2.Хурлын тов, хэлэлцэх асуудлын дарааллыг удирдах зөвлөл тогтооно.

26.3.Холбооны нийт гишүүдийн гуравны нэгээс дээш саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

26.4.Бүх гишүүдийн хурлын зарыг хурал болохоос 30 хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ. Хурлын зараар хурал болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудлын дарааллыг мэдээлнэ.

26.5.Холбоо олон гишүүнтэй бол хурлын зарыг энэ хуулийн 26.4-т зааснаас гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

26.6.Хэлэлцэх асуудалтай холбоотой урьдчилан судлах шаардлагатай материалыг бүх гишүүдийн хурал болохоос 5 хоногийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

26.7.ЗУдирдах зөвлөлөөс ээлжит бус хурлын товыг энэ хуулийн 26.2-т заасан санал гарснаас хойш 10 хоногийн дотор багтаан тогтоож, хэлэлцэх асуудлын дарааллыг тогтооно.

26.8.Удирдах зөвлөл нь ээлжит бус хурлын товыг энэ хуулийн 26.5-д заасан хугацаанд багтаан товлоогүй бол санаачилга гаргасан гишүүд хурлын товыг тогтоож болно.

26.9.Холбооны гишүүдэд ээлжит болон ээлжит бус хурлын зар хүрээгүй бөгөөд үүнийг санаатайгаар хүргүүлээгүй гэж үзвэл сонирхогч гишүүн энэ тухай шүүхэд гомдол гаргаж болно.

26.10.Шүүх энэ хуулийн 26.9-д заасан гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл хурлыг дахин хуралдуулах шийдвэр гаргаж, үүнтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээдээр төлүүлнэ.

27 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурал болон түүний шийдвэр хүчин төгөлдөр болох

27.1.Дүрэмд өөрөөр заагаагүй бол холбооны нийт гишүүдийн олонхи оролцсоноор бүх гишүүдийн хурал хүчин төгөлдөр болно.

27.2.Бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна.

27.3.Бүх гишүүдийн хуралд оролцох гишүүн байгууллагын төлөөллийг тухайн байгууллагын дүрэмд заасан эрх бүхий этгээд томилно.

27.4.Дараахь асуудлаар холбооны гишүүний саналын эрхийг хязгаарлаж болно:

27.4.1.нэг гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнтэй холбоотой асуудал хэлэлцэж байгаа;

27.4.2.тухайн гишүүн, эсхүл түүний ажилладаг хуулийн этгээдтэй холбоотой асуудал хэлэлцэж байгаа.

27.5.Бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэр хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

27.6.Дүрэмд өөрөөр заагаагүй бол хэлэлцэх асуудлын дараалалд ороогүй зүйлийг хурлаар хэлэлцүүлэхийг холбооны гишүүн санаачилж болох бөгөөд тухайн асуудлыг хэлэлцэх эсэхийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

27.7.Бүх гишүүдийн хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд түүнд хурал даргалагч болон хурлын тэргүүлэгчид гарын үсэг зурж баталгаажуулна.

27.8.Хурлын дарга хурлын тэмдэглэл үнэн, зөв хөтлөгдсөн эсэхийг хянаж, гарын үсэг зурна.

27.9.Хуралдааны тэмдэглэл дараахь мэдээллийг агуулсан байна:

27.9.1.хурал болсон, газар, огноо;

27.9.2.хурал даргалагчийн нэр;

27.9.3.хурлаар хэлэлцсэн асуудал;

27.9.4.хурлын ирц;

27.9.5.хэлэлцсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн, татгалзсан саналын тоо, гарсан шийдвэрийн бүрэн томъёолол.

27.10.Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хууль, холбооны дүрэмтэй зөрчилдсөн гэж үзвэл сонирхогч этгээд энэ тухай шүүхэд гомдол гаргаж болно.

28 дугаар зүйл.Удирдах зөвлөл

28.1.Удирдах зөвлөлийн гишүүдийг бүх гишүүдийн хурлаас сонгоно.

28.2.Удирдах зөвлөлийн гишүүдийн тоог дүрмээр тогтооно. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвлөлийн дарга, гишүүд, дүрэмд заасан бол хараат бус гишүүн байна.

28.3.Дүрэмд өөрөөр заагаагүй бол удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байна. Удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгох эсэхийг дүрмээр зохицуулна.

28.4.Хуульд зааснаас бусад тохиолдолд удирдах зөвлөлийн гишүүний эрх, үүргийг тухайн холбооны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлж болно.

29 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийн хурал

29.1.Удирдах зөвлөл нь бүх гишүүдийн хурлын өмнө ажлаа хариуцна.

29.2.Удирдах зөвлөлийн хуралдааны журмыг зөвлөл өөрөө тогтооно. Удирдах зөвлөлийг аль болох олон удаа хуралдуулах зарчим баримтална.

29.3.Удирдах зөвлөлийн хуралд оролцсон гишүүн бүр нэг саналын эрхтэй байна.

29.4.Удирдах зөвлөл холбоог төлөөлөн шийдвэр гаргах бөгөөд шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

30 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн даргын эрх, үүрэг

30.1.Удирдах зөвлөлийн дарга дараахь эрхтэй:

- 30.1.1.удирдах зөвлөлийн хурлыг даргалах;
- 30.1.2.бүх гишүүдийн хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөх;
- 30.1.3.холбооны дүрэмд заасан бусад.

30.2.Удирдах зөвлөлийн дарга нь дараахь үүрэгтэй:

30.2.1.холбооны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил бүр бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;

30.2.2.бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, холбооны гишүүдийн бүртгэлийн хөтлөлт хуульд заасан журмын дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих;

30.2.3.удирдах зөвлөлөөс зөвлөлийн гишүүнд өгсөн үүргийн биелэлтэд хяналт тавих;

30.2.4.холбооны дүрэмд заасан бусад үүрэг.

30.3.Удирдах зөвлөлийн даргад энэ хуулийн 30.1, 30.2-т зааснаас бусад нэмэлт эрх олгож, үүрэг хүлээлгэх бол холбооны дүрэмд заана.

31 дүгээр зүйл.Гүйцэтгэх захиралын эрх, үүрэг

31.1.Гүйцэтгэх захирал дараахь эрхтэй:

31.1.1.удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн хэлцэл хийх;

31.1.2.дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд холбооны эд хөрөнгө захиран зарцуулах шийдвэр гаргах;

31.1.3.холбооны дүрэмд заасан бусад.

31.2.Гүйцэтгэх захирал дараахь үүрэгтэй:

31.2.1.холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

31.2.2.нягтлан бодох бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хөтлөх ажлыг зохион байгуулах;

31.2.3.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагад хүргүүлэх;

31.2.4.холбооны гишүүдийн бүртгэлийн хөтлөх;

31.2.5.холбооны дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

31.3.Гүйцэтгэх захиралд энэ хуулийн 31.1, 31.2-т зааснаас бусад нэмэлт эрх олгож, үүрэг хүлээлгэх бол холбооны дүрэмд заана.

31.4.Гүйцэтгэх захирал үүргийг багийн зарчмаар гүйцэтгүүлж болно.

31.5.Гүйцэтгэх захирлын цалинг удирдах зөвлөлийн хурлаас тогтооно.

31.6.Гүйцэтгэх захирал нь үүргээ гүйцэтгэснийхээ төлөө холбооноос цалингаас гадуур нэмэлт урамшуулал авахыг хориглоно.

32 дугаар зүйл.Хяналтын зөвлөл

32.1.Хяналтын зөвлөлийг удирдах зөвлөлөөс томилно. Хяналтын зөвлөл нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хяналтын зөвлөлийн даргыг гишүүд дундаас томилно.

32.2.Хяналтын зөвлөл нь гүйцэтгэх захирлын болон холбооны санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд хяналт тавина.

32.3.Шаардлагатай тохиолдолд холбооны үйл ажиллагаанд аудит хийлгэх саналыг удирдах зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

32.4.Хяналтын зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг удирдах зөвлөлийн хурлаас тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

33 дугаар зүйл.Сан байгуулах

33.1.Сан байгуулахаар тохиролцсон этгээд үүсгэн байгуулах хурал зохион байгуулж, дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

- 33.1.1.сан байгуулах тухай шийдвэр гаргах;
- 33.1.2.сангийн дүрмийг батлах;
- 33.1.3.удирдах зөвлөлийг томилох.

33.2.Сан нь санхүүжилтийн журмаас хамаарч нийтийн, хувийн гэсэн төрөлтэй байна.

33.3.Зөвхөн дүрэмдээ заасан нэг, эсхүл хэд хэдэн этгээдээс хандивласан хөрөнгөөр санхүүждэг санг хувийн сан гэнэ.

33.4.Олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэх журмаар санхүүждэг санг нийтийн сан гэнэ.

33.5.Хувийн сан олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглоно.

33.6.Хувийн санг байгуулахад үүсгэн байгуулагч нь 10 сая төгрөгийг сангийн дансанд байршуулсан байна.

33.7.Нийтийн санг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрлийг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлөөс авна.

33.8.Нийтийн сан нь жил тутам санхүүгийн тайландаа аудит хийлгэнэ. Аудит хийлгэх зардлыг тухайн сан хариуцна.

33.9.Энэ хуулийн 33.7-д заасан Нийтийн сан байгуулах зөвшөөрөл олгох журмыг Иргэний хөгжлийг дэмжих зөвлөл батална.

34 дүгээр зүйл.Сангийн үүсгэн байгуулагч

34.1.Сан байгуулах тухай шийдвэр гаргаж, сангийн дүрмийг баталсан этгээдийг тухайн сангийн үүсгэн байгуулагч гэнэ. Сангийн үүсгэн байгуулагч удирдах зөвлөлийн гишүүн байж болно.

34.2.Дампуурлын хэрэг үүсгэгдсэн этгээд сан үүсгэн байгуулагч байхыг хориглоно.

34.3.Хувийн санг нэг этгээд үүсгэн байгуулж болно. Санг нэг этгээд үүсгэн байгуулж байгаа бол хөрөнгө, санхүүгийн байдлынхаа талаар 2-оос доошгүй этгээдээр тодорхойлолт гаргуулсан байна.

34.4.Сан байгуулагдсаны дараа тухайн санд хандив өгсөн, тусламж, дэмжлэг үзүүлсэн этгээдийг үүсгэн байгуулагчид тооцохгүй.

34.5.Үүсгэн байгуулагч болон энэ хуулийн 33.4-т заасан этгээдийн санд оруулсан хөрөнгө тухайн сангийн эд хөрөнгө болно.

34.6. Үүсгэн байгуулагч сангийн эд хөрөнгийг өмчлөх эрхгүй байна.

34.7. Сангийн хөрөнгийг дүрмийн бус зорилгоор ашиглах, бусдад зээлдүүлэх, сангийн удирдлага, ажилтны ашиг сонирхолын төлөө ашиглахыг хориглоно.

35 дугаар зүйл. Сангийн удирдлага, зохион байгууллалт

35.1. Сангийн эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна.

35.2. Сан нь хяналтын болон гүйцэтгэх байгууллагатай байна.

36 дугаар зүйл. Сангийн удирдах зөвлөл

36.1. Удирдах зөвлөл хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон 3-аас доошгүй төлөөллөөс бүрдэнэ.

36.2. Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааг дүрмээр тогтооно.

36.3. Удирдах зөвлөл гишүүд дотроосоо даргаа сонгоно.

36.4. Удирдах зөвлөлийн дарга, гишүүд үүргээ гүйцэтгэснийхээ төлөө тухайн сангаас цалин, урамшуулал авахгүй.

37 дугаар зүйл. Сангийн удирдах зөвлөлийн бүрэн эрх

37.1. Сангийн удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.1.1. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

37.1.2. санг өөрчлөн байгуулах, татан буулгах;

37.1.3. сангийн жилийн төсвийг батлах;

37.1.4. сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;

37.1.5. гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх түүнтэй гэрээ байгуулах, эд хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой эрх хэмжээг нь тодорхойлох;

37.1.6. хяналтын байгууллагыг томилох.

38 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн хурал

38.1. Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна. Ээлжит хурлыг удирдах зөвлөлийн дарга товлон.

38.2. Хяналтын байгууллагын шаардсанаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

38.3.Энэ хуулийн 38.2.-т заасны дагуу хяналтын байгууллага шаардлага гарснаас хойш удирдах зөвлөлийг 7 хоногийн дотор хуралдуулахаар тооцож, хурлын товыг тогтооно.

38.4.Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсоноор удирдах зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болно.

38.5.Удирдах зөвлөлийн хурлыг удирдах зөвлөлийн дарга, түр эзгүйд нь түүний даалгасан гишүүн удирдана.

38.6.Удирдах зөвлөлийн дарга, гишүүд хуралдааны тэмдэглэл үнэн, зөв хөтлөгдсөн эсэхийг хянаж, гарын үсэг зурна.

39 дүгээр зүйл.Удирдах зөвлөлийн шийдвэр

39.1.Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

39.2.Удирдах зөвлөлийн хуралд оролцсон гишүүн бүр нэг саналын эрхтэй байна.

39.3.Удирдах зөвлөл нь цөөн гишүүнтэй бөгөөд тэдгээр нь тодорхой асуудлаар адил саналтайгаа бичгээр илэрхийлсэн тохиолдолд хурал хийхгүйгээр уг асуудлаар шийдвэр гаргаж болно.

39.4.Удирдах зөвлөлийн хурал хийхгүйгээр гишүүдийн саналыг бичгээр авсны үндсэн дээр шийдвэрлэж болох асуудлыг удирдах зөвлөл тогтооно.

40 дүгээр зүйл.Хяналтын байгууллага, түүний эрх, үүрэг

40.1.Хяналтын байгууллага нэг, эсхүл хэд хэдэн гишүүнтэй байна.

40.2.Хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд сангийн гүйцэтгэх удирдлага байхыг хориглоно.

40.3.Хяналтын байгууллага нь гүйцэтгэх удирдлагын болон сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүрэгтэй.

40.4.Хяналтын байгууллагын бусад эрх, үүргийг сангийн үйл ажиллагааны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.

40.5.Хяналтын байгууллагыг мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэх удирдлага хариуцна.

41 дүгээр зүйл.Гүйцэтгэх удирдлага

41.1.Гүйцэтгэх удирдлага дараахь эрхтэй:

41.1.1.удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд санг төлөөлөх;

41.1.2.удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд сангийн эд хөрөнгийг захиран зарцуулах;

41.1.3.хууль, дүрэмд заасан бусад.

41.2. Гүйцэтгэх удирдлага дараахь үүрэгтэй байна:

41.2.1.сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх;

41.2.2.сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

41.2.3.хууль, дүрэмд заасан бусад.

41.2.Тухайн сангийн онцлогтой холбоотой гүйцэтгэх удирдлагад тусгай эрх олгож, үүрэг хүлээлгэх бол удирдах зөвлөлийн дарга гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОНЦЛОГ БҮХИЙ ХОЛБОО

42 дугаар зүйл.Мэргэжлийн холбоо

42.1.Засгийн газрын гишүүн, эсхүл Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын удирдлага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд ажиллах мэргэжлийн холбооны эрхийг олгоно.

42.2.Мэргэжлийн холбоо нь нийтийн эрх ашигт үйлчлэх зорилготой, тухайн салбарын хүрээнд тодорхой зохицуулалтад хамрагдах этгээдийн олонхийг, эсхүл олонхийг нэгтгэсэн гишүүнчлэлтэй байна.

42.3.Мэргэжлийн холбоонд тавигдах тусгай шаардлагыг холбогдох хуулиар тогтооно.

42.4.Мэргэжлийн холбооны гишүүн нь мэргэжилтэн, байгууллага, тэдгээрийг нэгтгэсэн холбоо байж болно.

42.5.Мэргэжлийн холбоо нь төрийн байгууллагатай дараахь хэлбэрээр хамтран ажиллахад давуу эрх эдлэнэ:

42.5.1.салбарын хүрээнд хэрэгжүүлэх бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, хэлэлцэх, хэрэгжүүлэх, хяналт тавих ажиллагаанд гишүүдээ төлөөлөн оролцох;

42.5.2.салбарын хүрээнд мэргэжлтийг бэлтгэх, мэргэжлийн арга зүйгээр хангах үйл ажиллагаа эрхлэх;

42.5.3.төрийн байгууллагаас олгосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх, мэргэжлийн зэрэг олгох, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах журам, ёс зүйн дүрмийг баталж, мөрдүүлэх.

42.6.Мэргэжлийн холбоо нь мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүй, хариуцлагын болон хяналтыг хэрэгжүүлэх дүрэмтэй байна.

42.7.Тухайн салбарт хэд хэдэн мэргэжлийн холбоо байж болно.

42.8.Салбарын онцлог, чиг үүргийн ялгаатай байдлыг харгалзан мэргэжлийн холбоонд энэ хуулийн 42.5-д зааснаас гадна тусгай давуу эрхийг холбогдох хуулиар олгож болно.

42.9.Төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 42.2, 42.3-д заасан шаардлагыг хангахгүй болсон, мөн энэ хуулийн 17.1.4-т заасан үндэслэлээр мэргэжлийн холбооны эрхийг хүчингүй болгоно.

42.10.Мэргэжлийн холбооны эрх олгох, хүчингүй болгох журмыг Засгийн газраас батална.

42.11.Мэргэжлийн холбоо нь энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан холбооны хэлбэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

43 дугаар зүйл.Эдийн засгийн холбоо

43.1.Өөрсдийн болон нийтийн эрх ашгийг хамгаалах, нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэх зорилгоор ашгийн төлөө хуулийн этгээдүүд нэгдэн эдийн засгийн холбоог байгуулж болно.

43.2.Эдийн засгийн холбоо нь энэ хуулийн 6.1, 6.2-т зааснаас гадна зах зээлд монополь, давамгайл байдал тогтоох, валют болон үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөхөд чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

43.3.Энэ хуулийн 43.1-д заасан үйл ажиллагаа явуулсан нь тухайн эдийн засгийн холбоог татан буулгах үндэслэл болно.

43.4.Эдийн засгийн холбоо нь энэ хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан холбооны хэлбэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ НИЙТЭД ТУСТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

44 дүгээр зүйл.Нийтэд тустай үйл ажиллагаа, түүний төрөл

44.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго, чиглэлтэй уялдуулан нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй болон төлбөргүйгээр эрхлэн гүйцэтгэж болно.

44.2.Дараахь үйл ажиллагааг нийтэд тустай үйл ажиллагаанд хамруулна:

44.2.1.нийгмийн хамгаалал /хүнд нөхцөлд байгаа хувь хүн, гэр бүл, ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ, ажил мэргэжил олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/;

44.2.2.эрүүл мэнд/нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирыг дэмжих үйл ажиллагаа/;

44.2.3.боловсрол/иргэний болон хүний эрхийн боловсролыг дэмжих, хүүхэд залуучуудын хөгжил, хүмүүжил төлөвшил, боловсролыг дэмжих, чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа/;

44.2.4.байгаль, хүрээлэн байгаа орчныг хамгаалах;

44.2.5.шинжлэх ухаан, технологийн дэвшлийг дэмжих;

44.2.6.нийгэм, эдийн засгийн хөгжлийг хөхиүлэн дэмжих;

44.2.7.ардчилалыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;

44.2.8.соёл, урлагийн болон түүх, өв, уламжлалыг хадгалж, хамгаалах, хөгжүүлэх;

44.2.9.ялгаварлан гадуурхалтыг устгах;

44.2.10.ядуурлыг бууруулах;

44.2.11.гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн үйл ажиллагаа;

44.2.12.цөөнхийн эрх ашгийг хамгаалах;

44.2.13.хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;

44.2.14 хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах;

44.2.15.үндэсний аюулгүй байдал, эв санааны нэгдэл, энх тайван найрамдалыг бэхжүүлэх;

44.2.16.нийгмийн сайн сайхны төлөө, сайн дурын үндсэн дээр ашгийн төлөө бус явуулж буй хууль ёсны бусад үйл ажиллагаа.

44.3.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь төлбөртэй гүйцэтгэсэн нийтэд тустай үйл ажиллагаанаас олсон орлогыг зөвхөн нийтэд тустай үйл ажиллагаанд зарцуулна.

44.4.Нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үйл ажиллагааны тайлангаа энэ хуулийн 13.3-т заасны дагуу Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд ирүүлнэ.

44.5.Энэ хуулийн 44.4-т заасан тайланд дараахь мэдээллийг тусгасан байна:

44.5.1 нэр, оршин байгаа хаяг;

44.5.2.нийтэд тустай үйл ажиллагааны чиглэл, зорилго, хэрэгжүүлсэн газар, хугацаа, үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, нийгмийн бүлгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар;

44.5.3.нийтэд тустай үйл ажиллагааны санхүүгийн тайлан.

44.6.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтэд тустай үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгүүлж болно. Аудитын зардлыг тухайн ашгийн төлөө бус хуулийн этгээд хариуцна.

45 дугаар зүйл.Нийтэд тустай үйл ажиллагааг баталгаажуулах

45.1.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл нь ашгийн төлөө бус хуулийн этгээдээс энэ хуулийн 13.3-т заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хянаад уг үйл ажиллагааны үр дүнг харгалзан дүгнэлт гаргаж баталгаажуулна.

45.2.Иргэний нийгмийн зөвлөл нь энэ хуулийн 13.3-т заасан тайланг өөрийн цахим хуудсанд 30 хоногийн хугацаанд байршуулах бөгөөд уг үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээллийг нээлттэй хүлээн авна.

45.3.Энэ хуулийн 45.1-д заасан дүгнэлтийг тухайн ашгийн төлөө бус хуулийн этгээдэд болон харьяа салбарын төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд зөвлөлийн цахим хуудсанд байршуулна.

45.4.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу Нийтэд тустай үйл ажиллагааны баталаа олгох журмыг Засгийн газар батална.

46 дугаар зүйл.Төрөөс нийтэд тустай үйл ажиллагаа эрхлэгч ашгийн төлөө бус хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэг

46.1.Төрөөс нийтэд тустай үйл ажиллагаа тогтмол, эсхүл хариу төлбөргүй эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдэд дараахь дэмжлэг үзүүлж болно:

46.1.1.иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн дүрмийн дагуу мөнгөн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлэх;

46.1.2.хуульд заасны дагуу төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг санхүүжилтын хамт давуу эрхтэйгээр гэрээний үндсэн дээр шилжүүлэх;

46.1.3.холбогдох хуульд заасан журмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийг давуу эрхтэйгээр ашиглуулах;

46.1.4.сайн дурын ажилтны үйл ажиллагаатай холбогдох урамшууллын зардлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх.

46.2.Нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө бус хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох татварын хуулиар зохицуулна.

46.3.Иргэний нийгмийг дэмжих зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн нийтэд тустай үйл ажиллагааг 2 жил, түүнээс дээш хугацаагаар эрхэлж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийг нийтэд тустай үйл ажиллагааг тогтмол эрхэлдэг гэж тооцно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ИРГЭНИЙ НИЙГМИЙГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛ

47 дугаар зүйл.Иргэний нийгмийг дэмжих зөвлөл

47.1.Иргэний нийгмийг дэмжих зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд төрийн байгууллагын болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөл бүхий 9 гишүүнтэй байна.

47.2.Соёл, шинжлэх ухааны, нийгмийн хамгааллын, санхүүгийн болон хууль зүй асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус бүр нэг гишүүнийг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд томилох эрхтэй.

47.3.Дараахь чиглэлд үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд өөр хоорондоо тохиролцон төлөөллийн нэг хүнийг зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:

47.3.1.хүний эрх, нийгмийн халамж;

47.3.2.боловсрол, соёл шинжлэх ухаан;

47.3.3.эрүүл мэнд, сонирхогчдын спорт;

47.3.4.байгаль орчныг хамгаалах.

47.4.Энэ хуулийн 47.3-т заасан нэр дэвшигч нь улс төрийн нам, хөдөлгөөн, шашны байгууллага болон аль нэг ашгийн төлөө хуулийн этгээдийг төлөөлдөг, эсхүл эдгээр байгууллагын үүсгэн байгуулагч, удирдах албан тушаалтан байхыг хориглоно.

47.5.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор томилж, чөлөөлнө.

47.6.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 5 жил байна. Зөвлөлийн гишүүнийг нэг удаа улируулан сонгож болно

47.7.Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө зөвлөл нөхөн нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

47.8.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн даргыг Ерөнхий сайд томилно.

47.9.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн ажлын алба нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцэнд ажиллана. Зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг Засгийн газар батална.

47.10.Иргэний нийгмийн зөвлөлийн дарга, гишүүн нь нийтийн албан тушаалтны нэгэн адил үүрэг хүлээнэ.

47.11.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болно. Урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

47.12.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх журмыг Засгийн газар батална.

48 дугаар зүйл.Иргэний нийгмийн дэмжих зөвлөлийн бүрэн эрх

48.1.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

48.1.1.Монголын иргэний нийгэм, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн чадавхыг дэмжих, дотоод засаглал, ёс зүйн жишгийг тогтоож хөгжүүлэх;

48.1.2.төрийн бодлого, шийдвэрийн төсөл боловсруулах, батлагдсан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хянахад иргэд, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн оролцоог хангах талаар төрийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвөлгөө өгөх, аргачлалаар хангах;

48.1.3.ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хөгжил, хамтын ажиллагаатай холбоотой нийтлэг асуудлаар төр болон олон улсын байгууллагуудтай харилцах;

48.1.4.бүртгэлийн болон статистикийн байгууллагуудтай хамтран ашгийн төлөө бус хуулийн этгээдийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийх;

48.1.5.ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтэд тустай үйл ажиллагааны болон сайн дурын тайлан авах, үйл ажиллагааны үр нөлөөг нэгтгэн дүгнэх;

48.1.6.ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нийтэд тустай үйл ажиллагааг баталгаажуулах;

48.1.7.Монгол Улсын иргэний нийгэм, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн мэдээллийн сан хөтлөх, олон нийтэд нийтлэх.

48.2.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлөөс үйл ажиллагаа идэвхитэй явуулж байгаа ашгийн төлөө бус хуулийн этгээдийн жагсаалтыг гаргаж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

48.3.Энэ хуулийн 48.1.7-д заасан мэдээллийн санг хөтлөх, түүний мэдээллийг ашиглах, сангаас мэдээлэл өгөх журмыг Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл батална.

49 дүгээр зүйл.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сан

49.1.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөл нь Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сантай байна.

49.2.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

49.2.1.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээд, иргэдээс санд оруулсан хандив, тусламж;

49.2.2.сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

49.2.3.бусад эх үүсвэр.

49.3.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих санд зориулж Монгол Улсын болон орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлж болно.

49.4.Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийг иргэний нийгмийн нийтлэг хөгжил, чадавхыг бэхжүүлэх болон нийтэд тустай үйл

ажиллагааг дэмжих, сурталчлах үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

49.5.Энэ хуулийн 49.1-д заасан сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Иргэний нийгмийн хөгжийг дэмжих зөвлөл батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

50 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

50.1.Ашгийн төлөө бус хуулийн этгээд нь энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд багтаан улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ.

50.2.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан зохицуулалтыг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн дараа дагаж мөрдөнө.

51 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

51.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг